

**НИЙСЛЭЛИЙН ОРОН СУУЦНЫ БОДЛОГЫН
ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 08 сарын 01-ний өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

**Архивын баримтад нэгдсэн тооллого
явуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.5 дахь заалт, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны А/222 дугаар тушаалаар батлагдсан Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журмын 7.1, 7.3, 7.4 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Байгууллагын архивын баримтад ээлжит тооллого явуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:	Б.Баялаг	Дотоод хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтэн
Гишүүд	Н.Еркежан	Төсөл хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн
	З.Мөнхзаяа	Орон сууцны судалгаа хариуцсан мэргэжилтэн
	Я.Долгор	Шуурхай үүрэг даалгавар, өргөдөл гомдол хариуцсан мэргэжилтэн
	Э.Ананд	Программ хангамж, сүлжээний ажилтан
	Х.Чанцалдулам	Бичиг хэрэг бөгөөд даргын туслах
Нарийн бичгийн дарга:	Г.Анударь	Архив, албан хэрэг хөтлөлт цахим мэдээллийн зохицуулалт хариуцсан мэргэжилтэн

2.Архивын баримтад тооллого явуулах үйл ажиллагааг хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулж, тооллогын нэгдсэн дүнг 2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор тайлагнахыг комисс (Б.Баялаг) -т даалгасугай.

**ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ**

Ж.БОЛОРТУЯА

